



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 2,275,000.00 (хоёр сая хоёр зуун далан таван мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга О.Бат-Өлзий нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 07 ны өдрийн
237 дугаар тогтоолын хавсралт



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ,
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн бүртгэлийн дугаар	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Суудлын автомашин /Бенз/	00000430	1998	ш	1	2,275,000.00
Нийт дүн					1	2,275,000.00 (хоёр сая хоёр зуун далан таван мянга)